

# “ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Хөвсгөл аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Л.Мөнх-Оргил  
Утас: 99039344 Цахим хаяг: [munkh-orgill@audit.gov.mn](mailto:munkh-orgill@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Ахлах аудитор: Г.Заяа  
Утас: 95648028, 98828028  
Цахим хаяг: [zaya96884510@gmail.com](mailto:zaya96884510@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/248  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Т.ЭНХБАЯР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс олгох санхүүжилтийг 112,075.4 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 640 хүүхдийн шинэ сургуулийн барилгыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын шийдвэрээр 15,040,945.4 мянган төгрөгөөр үнэлж данс бүртгэлд тусгажээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 25,292.6 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 2,578.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж холбогдох шийдвэрийг гаргасан болно.

### Бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 31 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 85 хувьтай тайлагнасан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан</i>		<i>/төгрөгөөр/</i>
<b>Балансын үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	767,243,552.07	547,033,035.53
МӨНГӨН ХӨРӨНГӨ	366,460,716.75	51,997,732.93
Төгрөг	366,460,716.75	51,997,732.93
Төрийн сангийн харилцах	366,460,716.75	51,997,732.93
АВЛАГА	2,131,932.02	2,131,932.02
Бусад авлага	2,131,932.02	2,131,932.02
Байгууллагаас авах авлага	2,131,932.02	2,131,932.02
БАРАА МАТЕРИАЛ	398,650,903.30	492,903,370.58
Түүхий эд материал	3,533,590.00	3,530,450.00
Эм боох материал	3,533,590.00	3,530,450.00
Хангамжийн материал	395,117,313.30	489,372,920.58
Бичиг хэргийн материал	26,283,512.00	36,830,952.00
Аж ахуйн материал	20,764,050.81	28,067,800.81
Сэлбэг хэрэгсэл	14,833,600.00	1,060,000.00
Түлш, шатах тослох материал	3,651,203.14	1,500,003.14
Барилгын засварын материал	20,303,857.86	25,177,557.86
Хүнсний материал	129,470,361.70	188,145,646.70
Бусад хангамжийн материал	179,810,727.79	208,590,960.07
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>767,243,552.07</b>	<b>547,033,035.53</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,880,560,236.06</b>	<b>17,602,647,495.65</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,880,560,236.06</b>	<b>17,602,647,495.65</b>
Биет хөрөнгө	2,806,809,738.97	17,530,279,495.65
Барилга, байгууламж, орон сууц	2,426,549,194.00	17,436,625,108.40
Хуримтлагдсан элэгдэл	-534,087,614.31	-928,823,036.38
Авто-тээврийн хэрэгсэл	79,800,000.00	79,800,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-5,320,000.00	-21,280,000.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	968,040,195.48	1,033,439,448.18
Хуримтлагдсан элэгдэл	-424,517,615.37	-364,598,096.79
Тавилга, аж ахуйн эд хогшил	392,607,102.47	372,922,700.19
Хуримтлагдсан элэгдэл	-134,887,457.12	-118,932,561.77
Бусад үндсэн хөрөнгө	4,917,484.00	2,500,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-4,917,484.00	00.00
Ном	38,625,933.82	38,625,933.82
Биет бус хөрөнгө	73,750,497.09	72,368,000.00
Програм хангамж	11,555,745.00	7,938,745.00
Хуримтлагдсан элэгдэл	-6,903,247.91	-4,668,745.00
Бусад биет бус хөрөнгө	69,098,000.00	69,098,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,647,803,788.13</b>	<b>18,149,680,531.18</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>60,778,806.23</b>	<b>201,708,888.63</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>60,778,806.23</b>	<b>201,708,888.63</b>
Өглөг	60,778,806.23	201,708,888.63
Бусад өглөг	60,778,806.23	201,708,888.63
Байгууллагад төлөх өглөг	60,778,806.23	201,708,888.63
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,587,024,981.90</b>	<b>17,947,971,642.55</b>
Засгийн газрын хувь оролцоо	3,587,024,981.90	17,947,971,642.55
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,231,441,861.00	1,231,441,861.00
Өмч: - төрийн	1,231,441,861.00	1,231,441,861.00
Хуримтлагдсан үр дүн	1,502,558,690.45	15,869,228,652.10
Өмнөх үеийн үр дүн	1,502,558,690.45	1,508,281,991.45

Тайлант үеийн үр дүн	00.00	14,360,946,660.65
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	853,024,430.45	847,301,129.45
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,647,803,788.13</b>	<b>18,149,680,531.18</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<b>4,436,617,322.20</b>	<b>20,093,206,757.30</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>4,412,652,822.20</b>	<b>15,357,622,257.30</b>
Нийтлэг татварын бус орлого	436,820,722.20	15,357,622,257.30
Төсөв байгууллагын өөрийн орлого	436,820,722.20	11,457,800.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,023,400.00	11,457,800.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	432,797,322.20	00.00
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,975,832,100.00	00.00
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,975,832,100.00	00.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>23,964,500.00</b>	<b>4,735,584,500.00</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	4,226,283,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	4,226,283,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	23,964,500.00	00.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,964,500.00	00.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	509,301,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	509,301,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,831,645,331.87	5,732,260,096.65
УРСГАЛ ЗАРДАЛ	3,831,645,331.87	5,732,260,096.65
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,672,213,877.87	5,517,910,739.65
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,601,479,272.21	3,434,920,765.82
Үндсэн цалин	1,705,843,397.07	1,984,353,789.11
Нэмэгдэл	751,888,797.86	1,157,510,274.22
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	101,446,489.87
Урамшуулал	143,747,077.28	191,610,212.62
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	354,479,053.69	436,566,900.00
Тэтгэврийн даатгал	241,149,215.18	296,864,900.00
Тэтгэмжийн даатгал	28,568,784.62	34,925,300.00
ҮОМШӨ-ний даатгал	14,126,841.56	17,463,000.00
Ажилгүйдлийн даатгал	14,126,842.30	17,463,000.00
Эрүүл мэндийн даатгал	56,507,370.03	69,850,700.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268,497,346.00	576,599,758.00
Гэрэл, цахилгаан	21,982,982.00	40,286,438.00
Түлш, халаалт	235,168,164.00	528,433,320.00
Цэвэр, бохир ус	11,346,200.00	7,880,000.00
Хангамж, бараа материалын зардал	59,309,049.32	37,597,850.40
Бичиг хэрэг	28,880,992.00	14,515,560.00
Тээвэр, шатахуун	23,276,807.32	23,082,290.40

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,151,250.00	00.00
Нормативт зардал	118,952,621.50	196,810,148.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	990,690.00
Хоол, хүнс	118,952,621.50	195,819,458.00
Эд хогшил, урсгал засварын зардал	17,148,181.00	24,501,100.00
Урсгал засвар	17,148,181.00	24,501,100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,995,646.23	40,779,018.89
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,364,811.83	17,317,958.89
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,630,834.40	23,461,060.00
Бараа үйлчилгээний бусад зардал	216,352,707.92	754,412,938.54
Бараа үйлчилгээний бусад зардал	23,074,728.87	74,319,173.11
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	9,537,200.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	193,277,979.05	670,556,565.43
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>159,431,454.00</b>	<b>214,349,357.00</b>
Бусад урсгал шилжүүлэг	155,774,500.00	230,071,617.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	127,960,500.00	199,447,317.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,814,000.00	30,624,300.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3656954.00	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,656,954.00	00.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>604,971,990.33</b>	<b>14,360,946,660.65</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>604,971,990.33</b>	<b>14,360,946,660.65</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,231,441,861.00	853,024,430.45	897,586,700.12	2,982,052,991.57
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	897,586,700.12	897,586,700.12
D01	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,231,441,861.00</b>	<b>853,024,430.45</b>	<b>1,502,558,690.45</b>	3,587,024,981.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,723,301.00	5,723,301.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,231,441,861.00</b>	<b>853,024,430.45</b>	<b>1,508,281,991.45</b>	3,592,748,282.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-5,723,301.00	00.00	-5,723,301.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	14,360,946,660.65	14,360,946,660.65
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,231,441,861.00</b>	<b>847,301,129.45</b>	<b>15,869,228,652.10</b>	17,947,971,642.55

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,003,820,000.00</b>	<b>4,747,042,300.00</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,979,855,500.00	11,457,800.00
Нийтлэг татварын бус орлого	4,023,400.00	11,457,800.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	4,023,400.00	11,457,800.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,023,400.00	11,457,800.00
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,975,832,100.00	00.00
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,975,832,100.00	00.00
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,964,500.00	4,735,584,500.00
Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	4,226,283,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	4,226,283,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	23,964,500.00	00.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,964,500.00	00.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	509,301,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	509,301,500.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,757,924,176.15</b>	<b>4,989,105,683.82</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	3,757,924,176.15	4,989,105,683.82
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,584,163,522.15	4,755,038,783.82
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,602,071,204.23	3,434,920,765.82
Үндсэн цалин	1,706,435,329.09	1,984,353,789.11
Нэмэгдэл	751,888,797.86	1,157,510,274.22
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	101,446,489.87
Урамшуулал	143,747,077.28	191,610,212.62
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	354,479,053.69	436,566,900.00
Тэтгэврийн даатгал	241,149,215.18	296,864,900.00
Тэтгэмжийн даатгал	28,568,784.62	34,925,300.00
ҮОМШӨ-ний даатгал	14,126,841.56	17,463,000.00
Ажилгүйдлийн даатгал	14,126,842.30	17,463,000.00
Эрүүл мэндийн даатгал	56,507,370.03	69,850,700.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268,497,346.00	498,801,500.00
Гэрэл, цахилгаан	21,982,982.00	43,871,246.00
Түлш, халаалт	235,168,164.00	452,615,784.00
Цэвэр, бохир ус	11,346,200.00	2,314,470.00
Нормативт зардал	166,633,320.00	194,920,500.00
Хоол, хүнс	166,633,320.00	194,920,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	32,407,300.00	10,500,000.00
Урсгал засвар	32,407,300.00	10,500,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,995,646.23	75,344,360.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,012,840.00	10,445,060.00

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,982,806.23	64,899,300.00
Бараа үйлчилгээний бусад зардал	124,079,652.00	103,984,758.00
Бараа үйлчилгээний бусад зардал	98,239,152.00	84,833,458.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,840,500.00	19,151,300.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>173,760,654.00</b>	<b>234,066,900.00</b>
Бусад урсгал шилжүүлэг	170,103,700.00	234,066,900.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,289,700.00	203,442,600.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,814,000.00	30,624,300.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,656,954.00	00.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,656,954.00	00.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>245,895,823.85</b>	<b>-242,063,383.82</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>200,437,493.77</b>	<b>72,399,600.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>200,437,493.77</b>	<b>72,399,600.00</b>
Дотоод эх үүсвэрээр	200,437,493.77	72,399,600.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	200,437,493.77	72,399,600.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-200,437,493.77</b>	<b>-72,399,600.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>45,458,330.08</b>	<b>-314,462,983.82</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	321,002,386.67	366,460,716.75
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	366,460,716.75	51,997,732.93

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	366,460,716.75	-
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,226,505,000.00</b>	<b>4,747,042,300.00</b>	<b>90.83</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,338,358,400.00	4,226,283,000.00	97.42
Улсын төсвөөс санхүүжих	4,338,358,400.00	4,226,283,000.00	97.42
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	509,301,500.00	509,301,500.00	100.00
Орон нутгийн төсвөөс	509,301,500.00	509,301,500.00	100.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	378,845,100.00	11,457,800.00	3.02
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,397,000.00	11,457,800.00	92.42
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	366,448,100.00	-	-
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,226,505,000.00</b>	<b>5,061,505,283.82</b>	<b>96.84</b>
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,226,505,000.00	5,061,505,283.82	96.84
Бараа, үйлчилгээний зардал	4,986,438,100.00	4,827,438,383.82	96.81
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,552,858,000.00	3,434,920,765.82	96.68
Үндсэн цалин	2,172,966,300.00	1,984,353,789.11	91.32
Нэмэгдэл	1,247,824,300.00	1,157,510,274.22	92.76
Унаа, болон бусад нөхөн олговор	-	101,446,489.87	-
Урамшуулал	132,067,400.00	191,610,212.62	145.09
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	445,019,000.00	436,566,900.00	98.10
Тэтгэврийн даатгал	302,612,800.00	296,864,900.00	98.10
Тэтгэмжийн даатгал	35,601,500.00	34,925,300.00	98.10
ҮОМШӨ ний даатгал	17,800,900.00	17,463,000.00	98.10
Ажилгүйдлийн даатгал	17,800,900.00	17,463,000.00	98.10

Эрүүл мэндийн даатгал	71,202,900.00	69,850,700.00	98.10
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	498,801,500.00	498,801,500.00	100.00
Гэрэл цахилгаан	35,380,700.00	43,871,246.00	124.00
Түлш, халаалт	461,106,300.00	452,615,784.00	98.16
Цэвэр, бохир ус	2,314,500.00	2,314,470.00	100.00
Нормативт зардал	224,920,500.00	194,920,500.00	86.66
Хоол, хүнс	224,920,500.00	194,920,500.00	86.66
Эд хогшил худалдан авах	10,500,000.00	10,500,000.00	100.00
Урсгал засвар	10,500,000.00	10,500,000.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	76,681,900.00	75,344,360.00	98.26
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,445,100.00	10,445,060.00	100.00
Мэдээллийн технологийн зардал	66,236,800.00	64,899,300.00	97.98
Бараа үйлчилгээний бусад зардал	177,657,200.00	176,384,358.00	99.28
Бараа үйлчилгээний бусад зардал	158,505,900.00	157,233,058.00	99.20
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,151,300.00	19,151,300.00	100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>240,066,900.00</b>	<b>234,066,900.00</b>	<b>97.50</b>
Бусад урсгал шилжүүлэг	240,066,900.00	234,066,900.00	97.50
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	209,442,600.00	203,442,600.00	97.14
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	30,624,300.00	30,624,300.00	100.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>366,460,716.75</b>	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>51,997,732.93</b>	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,604.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 24,604.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд өөрийн орлогыг 1,025.0 мянган төгрөгөөр, үдийн хоолны зардлыг 3,062.4 мянган төгрөгөөр, дотуур байрны хоолны зардлыг 15,722.6 мянган төгрөгөөр тус тус алдаатай тайлагнасныг захирал, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрч залруулга хийсэн.
- ✓ Нэр бүхий ажилтнуудад 4,794.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон зөрчлийг аудитын хугацаанд орон нутгийн төсвийн дансанд төлж барагдуулсныг залруулгаар бүртгэлээ.

Аудитаар нийт 1,401,191.1 мянган мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6,319.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 3,082.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 1,391,789.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Нэр бүхий 3 ажилтанд 5,379.0 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон, нэг ажилтанд 940.7 мянган төгрөгийн балансын урамшууллыг ажлыг дүгнэлгүйгээр олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

“нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Хариуцлага тооцох албан шаардлага

1. Төсвийн шууд захирагч нь 2025 оны Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.3 Албан шаардлага

1. Тээвэр шатахууны зардлын батлагдсан төсвийг 3,082.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 6.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Арвилан хэмнэлт, үр ашигтай холбоотой асуудал

##### 1.Илрүүлэлт:

Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг захиргаа аж ахуйн ажилтнуудад хуваарилахдаа ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнг харгалзалгүйгээр харилцан адилгүй хуваарилдаг, ялангуяа захиралд олгосон урамшууллын хэмжээ нь холбогдох хууль журамд заасан хэмжээнээс хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн, " үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

##### Өгсөн зөвлөмж:

Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг захиргаа аж ахуйн ажилтнуудад хуваарилахдаа ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнг харгалзах, сургуулийн удирдлагын багийн гишүүдэд олгохдоо хууль журамд зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн олгодог зөрчлийг таслан зогсоох,

#### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

##### 2.Илрүүлэлт:

Эд хариуцагч бараа материалын тайланг хугацаанд нь гаргаагүй, хүнсний материалын зарцуулалтыг 15,890.6 мянган төгрөгөөр алдаатай гаргасан, нягтлан бодогч нь эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байна" гэж заасныг зөрчсөн, "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд үнэн зөв гаргах, нягтлан бодогчид эд

хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон баримт үйлдэж хэвших үүргүүдийг хүргүүлэн биелэлтийг тооцох;

### Нийцлийн аудиттай холбоотой асуудал

#### 3.Илрүүлэлт:

Байгууллагад 2025 оны 12 дугаар сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажлаас чөлөөлсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээг байгуулаагүй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д “Мэдээлэл хариуцагч ажлын байрны сул орон тооны талаарх Мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.” гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

#### Өгсөн зөвлөмж:

Байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд зарлах, ажлаас чөлөөгдсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулан, цалин хөлсийг олгох;

#### 4.Илрүүлэлт:

Дотоод хяналтын нэгж нь тайлант онд 11 ажил төлөвлөсөн боловч 3 ажлын гүйцэтгэж, хэрэгжилт 27.2 хувьтай, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн боловч биелэлтийг нь тооцоогүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.3, 3.7.8 зэрэг заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгжид төлөвлөсөн хяналт шалгалтыг бүрэн хийх, хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх үүргүүдийг өгч биелэлтийг тооцох;

#### 5.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 424,009.9 мянган төгрөгөөр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг 924,585.2 мянган төгрөгөөр, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 24,724.8 мянган төгрөгөөр тус тус дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй .

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,тайлан, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Хүснэгт 6. Завсрын аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	188,453.9			1	188,453.9	1	188,453.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>188,453.9</b>			<b>1</b>	<b>188,453.9</b>	<b>1</b>	<b>188,453.9</b>				

**Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланг алдаатай гаргасан	1	19,810.0			1	19,810.0	1	19,810.0				
Нэр бүхий ажилтнууд ацалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон зөрчлийг орон нутгийн төсвийн дансанд төлж барагдуулсан	1	4,794.0			1	4,794.0	1	4,794.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>24,604.0</b>			<b>2</b>	<b>24,604.0</b>	<b>2</b>	<b>24,604.0</b>				

**Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий ажилтнуудад цалингийн нэмэгдэл, ээлжийн амралтын олговрыг илүү тооцож олгосон	1	6,319.7	1	6,319.7				
тээвэр шатахууны зардлыг батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан	1	3,082.3			1	3,082.3		
Эд хариуцагч бараа материалын тайланг хугацаанд нь гаргаагүй, хүнсний материалын зарцуулалтыг алдаатай бүртгэсэн	1	15,890.6					1	15,890.6
Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд бэлтгэж ирүүлээгүй;	1	0.0				1	0.0	
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>25,292.6</b>	<b>1</b>	<b>6,319.7</b>	<b>2</b>	<b>3,082.3</b>	<b>1</b>	<b>15,890.6</b>

**Хүснэгт 9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн.								
Удирдлагын багийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг журмын дагуу олгоогүй	1	2,578.5					1	2,739.7
2025 оны 12 дугаар сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй	1	0.0					1	0.0
дотоод хяналтын нэгж нь 11 ажил төлөвлөсөн боловч аудитад 3 ажлын тайланг ирүүлсэн.	1	0.0					1	0.0
Шилэн дансны тухай хууль зөрчигдөх	1	1,373,319.9					1	1,373,319.9
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>1,375,898.5</b>					<b>4</b>	<b>1,375,898.5</b>